




Хүн ам орон сууцны 2020 оны улсын тооллого Асуулгын хуудас бөглөх заавар



Улсын тооллогын зорилт болон асуултад хариулах аргыг жичид нь тайлбарласан тул “Асуулгын хуудсын орчуулга” ба “Асуулгын хуудас бөглөх заавар”-ын 2-8-р хуудсыг харж байгаад япон хэл дээрх асуулгын хуудсыг бөглөнө үү.

Бөглөсөн хариулт нь зөвхөн статистикийн зорилгот ашиглагдах бөгөөд оршин суухыг хянах, цагдан сэргийлэх албанаас эрж, хайх гэх мэт бусад зорилгоор ашиглагдахгүй болно.

- 調査員の方は、世帯の人から『外国語連絡票』の **H** で示された調査票の提出方法と回収日時
の同じ部分にチェック (☑) を付けてから、この『調査票の記入のしかたの対訳』を世帯の人
に渡してください。

Асуулгын хуудсыг буцааж тушаах арга

- Асуулгын хуудсыг ажилтанд биечлэн өгөх** (調査員に提出) … 世帯が『外国語連絡票』の **H** で **6** を示した場合

Таны бөглөсөн асуулгын хуудсыг дараах цагуудад авахаар ирэх болно.

- 10 сарын 1-ний өдөр (Пүрэв) 2 өдөр (Баасан) 3 өдөр (Бямба) 4 өдөр (Ням) 5 өдөр (Даваа) 6 өдөр (Мягмар) 7 өдөр (Лхагва)

- Үдээсөмнө 8~10 цаг 10~12 цаг Үдээсхойш 0~2 цаг 2~4 цаг 4~6 цаг 6~8 цаг

- Шуудангаар явуулах бол** (郵送で提出) … 世帯が『外国語連絡票』の **H** で **7** を示した場合
Япон хэл дээрх бөглөсөн асуулгын хуудсыг 3 нугалаад дугтүйд хийж, марк наалгүйгээр 10 сарын 7-ний өдөр (Лхагва гараг) хүртэл ойролцоох шуудангийн хайрцагт хийнэ үү. Заагдсан хугацаа хүртэл шууданд хийгээгүй бол дараа дахин ирж асуулгын хуудсыг авна.

Хүн ам, орон сууцны тооллогын тухай

2020 оны 10 сарын 01-ний өдрийн байдлаар, орон даяар нэгэн зэрэг Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулна.

Хүн ам, орон сууцны улсын тооллого гэдэг нь Статистикийн тухай хууль хэмээх хуулинд үндэслэн засгийн газраас зохион байгуулж явуулдаг маш чухал тооллого бөгөөд иргэний харьяалал харгалзалгүй, Японд амьдарч байгаа бүх хүмүүс үүнд хамрагдана.

Дээрх Статистикийн тухай хуулиар бүх хүмүүс асуулгын хуудсыг бөглөж өгөх үүрэг хүлээсэн байдаг.

Мөн, тооллогын ажилтан болон тооллогын ажилд оролцож байгаа ажилтнууд нууцыг чандлан хадгалах үүрэг хүлээнэ.

Таны бөглөсөн асуулгын хуудыг гадагш задлахгүйгээр чандлан хамгаалж, тооллого дууссаны дараа бүрэн устгана.

Улсын тооллогын дүн нь гадаадын оршин суугчдын хувьд ч амьдрах таатай орчин бүрдүүлэх зэрэг бодлогын суурь материал болж мөн ашиглагдана.


Асуулгын хуудсыг өрх тус бүрээр бөглөнө.

- ◆Энгийн гэр бүл шиг хамт амьдарч, өрхийн тооцоогоо хамт хийж буй хүмүүсийг нэг өрх гэж үзнэ.
- ◆Ганцаараа амьдарч байгаа хүнийг мөн нэг өрх гэж үзнэ.

- Дараах хүмүүсийн өрхийг тус тус доорх байдлаар тодорхойлно.
 - Хажуу өрөөнд түрээсээр амьдрагч, хамтдаа нэг байр нийлж хөлсөлдөг хүн:
 - ……ганц бие бол ганцаараа нэг өрх гэж үзнэ.
ах дүү нарын гэр бүлүүд хамт амьдарч байгаа бол гэр бүл тус бүрийг нэгөрх гэж үзнэ.
 - Гэрийн ажилчны хувиар хамт амьдарч байгаа:
 - ……Хөлсөлж буй эзний гэрт хамт амьдарч байгаа бол үг хөлсөлж буй эзний гэр бүлд оруулж тооцно.
Хөлсөлж буй эзнээс өөр сууцанд амьдардаг бол тусад нь нэг өрх гэж үзнэ.
 - Компани болон албан байгууллагын ганц биеэр амьдрах байр, дотуур байранд ганцаар амьдарч байгаа хүн:
 - ……ганцаараа нэг өрх гэж тооцно.

Асуулгын хуудсыг бөглөх тухайд

- Асуулгынхуудсыгхарбалын харандаагаар бөглөнө үү.
- 「○」 тэмдгийг 「●」 тэмдэг шиг будаж бөглөнө үү.
- Тоогдөрвөлжиндотроос хальж гарахгүйгээр, баруун талыг барьж бичнэ үү.



Асуулгын хуудсын 1-р нүүрийг бөглөх заавар

Өрхийн талаар

1. Өрхийн гишүүдийн тоо

Өрхийн гишүүдийн тоо 5 хүнээс дээш бол асуулгын хуудсын 1-р нүүрэнд өрхийн бүх гишүүдийн тоог бичнэ үү.

2. Байр сууцны төрөл

Өөрийн байр, сууц: Өөрийн өмчлөлийн байр сууцыг хэлнэ. Бүртгүүлээгүй буюу урт хугацааны зээлээр аваад уг зээлээ төлж дуусаагүй байсан ч үүнд хамааруулна.

Хот байгуулалтын газар, албан байгууллагууд зэргийн мэдлийн хөлсний байр:

Хот байгуулалтын газар, нийслэл, аймаг, муж, хот, дүүрэг, тосгон, суурингийн орон сууц хангалт хариуцсан албан байгууллага, холбоо зэргүүдийн хөлслүүлдэг байр орон сууцнуудыг хэлнэ. Гэхдээ “компаний байр, төрийн албан хаагчдын байр”-ыг үүнд хамааруулахгүй.

Компаний байр, төрийн албан хаагчдын байр:

Тухайн ажиллаж буй компани, төрийн албан байгууллага, ажиллуулж буй байгууллага зэрэг газруудын мэдлийн буюу тэдгээр байгууллагын түрээсэлдэг сууцанд амьдардаг бол үүнийг бөглөнө.

Хажуу өрөө: Өөр бусад өрх гэр бүл амьдардаг сууцны нэг хэсэгт амьдардаг бол үүнийг бөглөнө. Гэхдээ уг амьдарч буй хэсэг нь дараах ① ба ②-н аль алинд нь хамаарах тохиолдолд “Хувийн байгууллага, хувь хүмүүсийн хөлслүүлдэг байр” гэж үзнэ.

Компаний ганц хүний байр, дотуур байр зэрэг:

Ганц биеэр томилогдон ажиллаж буй ажилтан, ажилчдын амьдрахад зориулан, компани, албан байгууллага, байгууллагуудын эзэмшиж буй буюу түрээсэлж буй сууцыг хэлнэ. Гэхдээ уг амьдарч буй хэсэг нь дараах ① ба ② -н аль алинд нь хамаарах тохиолдолд “Компаний байр, төрийн албан хаагчдын байр” гэж үзнэ.

- ① Бусад өрхийн амьдардаг хэсгээс бүрэн тусгаарлагдсан байвал
- ② Танай өрхийн зориулалтын орох гарах хаалга, гал тогооны тосгуур, бие засах газартай бол.
(Бусад өрхтэй дундаа ашигладаг ч гэсэн тэдгээр өрхийн амьдардаг хэсгээр дайралгүйгээр дуртай үедээ хэрэглэж болохоор байдалтай байхыг мөн үүнд хамааруулна.)

Өрхийн бүх гишүүдийн талаар

3. Овог нэр, хүйс

- 2020 оны 10 сарын 01-ний өдрийн 12 цаг хүртэлх хугацаанд мэндэлсэн нярай хүүхэд бөгөөд нэр өгч хараахан амжаагүй тохиолдолд нэр бичих дөрвөлжингийн дотор нэр өгөөгүй байгаа (reimeime) хэмээн бичиж, хүйсийг тэмдэглэнэ үү.

- Байнга оршин суудаг хүн гэдэг нь гадаадын оршин суугчаар бүртгүүлсэн эсэхээс үл хамааран, 10 сарын 1-ний байдлаар таны өрхөд байгаа дараах хүмүүсийг хэлнэ:
- ◆ 3 сараас дээш амьдарч байгаа хүн
 - ◆ 3 сар болоогүй боловч 3 сараас дээш хугацаагаар оршин суух хүн

- Таны гэр бүлийн хүн биш ч танай өрхөд 3 сараас дээш байрлаж байгаа, эсвэл байрлахаар болсон хүн байвал тухайн хүнийхээ талаар мөн бичнэ үү.
- Дараах хүмүүс нь тус тусын байрлаж буй доорх газруудад тооллогод хамрагдана.
 - Танай гэр бүлийн дотор дараах хүмүүс байгаа тохиолдолд асуулга бөглөхдөө анхааралтай бөглөнө үү.
 - Аялал, томилолт, өөр газар ажиллахаар явсан зэрэг түр хугацаагаар эзгүй байгаа хүмүүс:
 - Гэртээ байхгүй байх хугацаа нь 3 сар хүрэхгүй бол гэртээ тоолуулна.
 - гэртээ байхгүй байх хугацаа нь 3 сараас дээш бол аялж байгаа газар, томилолтоор ажиллаж байгаа газар, ажиллаж байгаа газартаа тоолуулна.
 - Сургуулийн сурагчийн дотуур байр зэргээс сургуульдаа явдаг оюутан, сурагчид:
 -Тухайн дотуур байр зэрэг газартаа тоолуулна.
 - Эмнэлэг, сувилалд байгаа хүмүүс:
 -Эмнэлэгт хэвтээд 3 сар болоогүй бол гэртээ тоолуулна.
 -Эмнэлэгт хэвтээд 3 сараас дээш болсон бол эмнэлэгтээ тоолуулна.

- Усан онгоцоор явж байгаа хүн: ……Гэртээтоолуулна.

- Хорих газар, түр саатуулах газарт хоригдож байгаа хүмүүсийн дотроос ял заагдсан байгаа хүмүүс,
- Хүүхдийн засан хүмүүжүүлэх газар, эмэгтэйчүүдийн хорих газарт хоригдож байгаа хүмүүс:
……Тус тусын хоригдож байгаа газартаа тоолуулна.

- 3 сараас дээш хугацаагаар тодорхой оршин суусан газаргүй, цаашид оршин суух газаргүй хүмүүс:
……Одоо байгаа газартаа тоолуулна.

- 2 газар сууцтай хүн:
……Аль илүү очиж хонодог сууцандаа тоолуулна.

4. Өрх толгойлогчтой ямар барилдалгаатай вэ

Өрхийн гишүүдийн дундаас нэгийг “өрх толгойлогч буюу төлөөлөгч” болгоно.

Өрхийн бусад гишүүд “өрх толгойлогч буюу төлөөлөгч”-ийн байрнаас харахад уг хүний юу нь болохыг бөглөж тэмдэглэнэ үү.

Бусад садан төрөл: Өвөг эцэг, эмэг эх, ачийнхүүхэд, аав ээжийн ах эгч дүү, ах эгч дүүгийн хүүхэд, үеэл, садангийн ах эгч дүү (эдний эхнэр, нөхөр мөн хамаарна) г.м.

Бусад: Найзынхаа хүүхдийг түр амьдруулж байгаа зэрэг садангаас бусад хамт амьдарч байгаа хүмүүс (хамт амьдардаг гэрийн ажилчныг тооцохгүй)

7. Иргэний харьяалал

2-с дээш улсын иргэншилтэй хүний аль нэг иргэншил нь “япон” бол “Япон” гэж үзнэ.

Япон улсын иргэншилгүй хүн бол аль нэг улсынхаа нэрийг

(улсыннэр)

Дөрвөлжин дотор бичнэ үү.

8. Одоо байгаа газартаа амьдарч буй хугацаа

Одоогийн газартаа амьдарч эхэлснээс хойш ажил шилжих, ганц биеэр томилолтоор явах, аялал, түр томилгоо, орлого олохоор өөр газар луу ажиллахаар явсан зэрэг 3 сараас дээш хугацаагаар эзгүй байсан бол тухайн эзгүй байсан хугацааны дараа одоогийн амьдарч байгаа газартаа буцаж ирснээс хойших хугацаанд харгалзах хэсгийг сонгож тэмдэглэнэ үү.

9. 5 жилийн өмнө(2015 оны 10 сарын 1-ний байдлаар) хаана амьдарч байсан бэ.

5 жилийн өмнө (2015 оны 10 сарын 1-ний байдлаар) амьдарч байсан газраа бичнэ үү.

➤ 2020 оны 10 сарын 01-ний байдлаар төрөх эмнэлгээс гараагүй байгаа шинээр төрсөн хүүхдийн хувьд эмнэлгээс гарснаас хойш амьдрах газрыг нь бичнэ үү.

➤Токио хотын дүүргүүд гэдэг нь дараах 23 дүүргийгхэлнэ.

（ Чиеодакү , Чюү-оо-кү, Минатоку, Шинжюкүкү, Бүнкёокү, Дайтоокү, Сүмидакү, Коотоокү, Шинагавакү, Мэгүроку, Оотайкү, Сэтагаякү, Шибүякү, Наканокү, Сүгинамикү, Тошимакү, Китаку, Аракавакү, Итабашику, Нэримакү, Адачикү, Кацүшикакү, Эдогавакү. ）

Асуулгын хуудсын 2-р нүүрийг бөглөх заавар

Өрхийн бүх гишүүдийн талаар

11. 9 сарын 24-с 30 хүртэлх 1 долоо хоногийн хугацаанд ажил хийсэн үү?

9 сарын 24-с 30 хүртэлх 1 долоо хоногийн хугацаанд цалин хөлстэй ажил бага ч гэсэн хийсэн хүмүүс дээд талын хэсэг, цалин хөлстэй ажил бага ч гэсэн хийгээгүй хүмүүс доод талын хэсгийн дотроос өөрх харгалзах хэсгийг зөвхөн 1-ийг сонгож тэмдэглэнэ үү.

“дадлагажигч”-ийн визээр оршин сууж буй хүмүүс ээс бэлтгэл сургуулилтын хугацаандаа байгаа хүмүүс “сургуульд сурдаг” гэсэн хэсгийг бөглөнө үү.

Гэрийн ажилтай хүмүүс ...Голчлон гэрийн ажил хийдэг боловч хажуугаар нь гэрээний түр ажил хийдэг, бас өөрийн гэр бүлийн хувийн аж ахуйд туслах, гэрээрээ орлого олох ажил хийх зэргээр цалин хөлстэй ажил бага ч гэсэн хийсэн бол эдгээрийг хэлнэ.

Амралттай байсан Ажил хийдэг хүн өвчин тусах юм уу амралт авах зэргээр ажлаа түр хийгээгүй болон ажилгүйдлийн даатгалын хууль, хүүхэд өсгөх амралтын хуулийн дагуу олгогдох мөнгө авахаар болсон бол мөн үүнд хамааруулна. Бас хувиараа бизнес эрхэлдэг хүн өвдөх, түр амралт авах зэргээр ажлаа хийгээгүй хугацаа нь 30 хоногоос доош бол.

Ажил хайж байсан..... Ажилгүйдлийн улмаас Хароваакү(Олон нийтийн ажлын байрны үйлчилгээний газар)-д ажил хайж байгаа тухайгаа бүртгүүлсэн, сонин зэрэг дээрх ажлын байрны зарын дагуу ажилд орохоор хандсан, хүмүүсээс ажилд танилцуулахыг гүйх зэргээр ажил олохоор идэвхтэй хайж байгааг хэлнэ. Гэхдээ зөвхөн ажил олдсон үед уг ажилд шууд орохоор байгаа тохиолдлыг үүнд хамааруулна.

Сургуульд сурдаг.....Япон хэлний курс, хоол хийж сурах курс зэрэгт долоо хоногт 1 буюу 2 удаа явдгийг үүнд хамааруулахгүй.
➤ Цэцэрлэг, хүүхэд асрах газар болон хүүхэд асрах зөвшөөрөл авсан бусад байгууллагад очиж харуулдаг бол “Бусад” гэдгийг бөглөнө.

Ажил хийдэг, сургуульд сурдаг хүмүүсийн талаар

12. Ажлын газар, сургуулийн байршил

- Ажилангаа сурдаг бол ажлын газрынхаа хаана байдгийг бичнэ үү.
 - Токио хотын дүүргүүдэд байдаг бол 4-р хуудасны “9. 5 жилийн өмнө (2015 оны 10 сарын 1-ний байдлаар) хаана амьдарч байсан бэ” гэсэн асуултын доорх тайлбарыг үзэж байгаад бичнэ үү.

- Дараах хүмүүс тус тус доорх байдлаар өөрсдийн ажлын байрны байршлыг тодорхойлно уу.
 - Өөрийн гэр бүлийн тариа ногооны талбай, ой, загасчлах завин дээр ажилладаг хүмүүс:
 - … “Гэртээ” гэснийг бөглөнө.

 - Хувиараа мужаан, явуулын худалдаа үйлчилгээ хийдэг хүмүүс:
 - … “Гэртээ” гэснийг сонгож бөглөнө.

 - Гадуур цалинтай ажил хийдэг хүмүүс:
 - … Уг хөлслөгдөж буй газрынхаа байдаг хот, дүүрэг, тосгон, сууринг бичнэ. (Гадуур явдаг ажилтай ажилтнууд, жолооч зэрэг)

 - Усан онгоцон дээр ажилладаг хүмүүс:
 - … Уг усан онгоцныхоо голчлон зогсдог боомтын харьяалагддаг хот, дүүрэг, тосгон, сууринг бичнэ.

13. Ажил болон сургууль байгаа газар луу явахад үйлчилдэг нийтийн тээврийн хэрэгсэл

- Үйлчилдэг нийтийн тээврийн байгууллага нь солигдож байгаа бол ихэнхдээ ажилладаг нийтийн тээврийн байгууллагынхаа нэрийг тэмдэг тавьж тодорхойлно уу.
- “очих ба ирэх” дээ үйлчлүүлдэг нийтийн тээврийн байгууллага нь солигдож байгаа бол “очих” гэсэн хэсэгт тэмдэг тавьж тодорхойлно уу.

Ажилладаг хүмүүсийн тухайд

14. Цалин авч ажилладаг уу, хувиараа ажил, бизнес эрхэлдэг үү.

Цалин авч ажилладаг хүн: …Компани, байгууллага, албан газар, хувийн байгууллага, дэлгүүр зэрэгт цалинтай ажилладаг хүнийг хэлнэ.

Томилгооны ажилтан: …“Гэрээний ажилчин, цагийн ажилчин” зэргээр дуудагддаг байсан ч “Томилгооны ажилтан” гэж үзнэ.

Компаний дээд албан тушаалтан: …Компаний захирал, ерөнхий захирал, хяналтын ажилтан, байгууллага, олон нийтийн ашгийн корпораци, бие даасан захиргааны байгууллагын захирал, аудитор зэрэг удирдах дээд албан тушаалын хүмүүс.

➢ Хэлтэс, тасгийн дарга зэрэг удирдах, хэрэгжүүлэх албан тушаалтны хувьд захирал, ерөнхий захирал зэрэг дээд албан тушаалтан биш бол “цалинтай ажилладаг хүн” гэж үзнэ.

Хувиараа аж ахуй эрхлэгч: …Ажилтан авч ажиллуулдаг бол “Ажилчин авч ажиллуулдаг”, ажилтан авч ажиллуулдаггүй бол “Ажилчин байхгүй” –г бөглөнө.

➢ Хувиараа дэлгүүр ажиллуулдаг, уг дэлгүүр нь компанийн зохион байгуулалтад байдаг(ХК ба ХХК, хувь нийлүүлсэн, нэр нийлүүлсэн, хамтарсан компани) бол “Компаний удирдах зөвлөлийн гишүүн” хэсгийг бөглөнө.

Гэрийн ажилтай:Газар тариалан, хувийн дэлгүүр зэрэгт тариа ногооны ажил болон дэлгүүрийн ажилд тусалдаг гэр бүлийн хүмүүс.

Гэртээ авчирч хийдэг ажил:Хийх материалыг хүлээн аваад том хэмжээний тусгай багаж төхөөрөмж зэрэг хэрэглэхгүй ажлыг гэртээ ганцаараа хийдэг бол энэ хэсэгт тэмдэглэнэ.

15. Ажлын байрны нэр

- Тухайн ажилладаг газар(Төв компани, салбар, хэсэг, үйлдвэр, дэлгүүр)-ынхаа нэрийг бичнэ үү.
 - Салбар, хэсэгт ажилладаг бол Компанийн нэр төдийгүй өөрийн яг ажилладаг салбар, хэсгийнхээ нэрийг ч мөн бичнэ үү.
 - 2-с дээш ажлын байранд ажилладаг бол илүү удаан цагаар ажилладаг ажлын байрныхаа нэрийг бичнэ үү.
 - Томилгооны ажилтны хувьд томилогдон очиж ажиллаж байгаа ажлын газрынхаа нэрийг бичнэ үү.

15. Ажлын байранд хийгддэг ажлын агуулга

- Уг ажлын байран дээр голчлон хийгддэг ажлын агуулгыг бичнэ үү.
- Гол бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл юу болох, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үү, эсвэл засварладаг үү гэдгийн ялгааг гаргаж, бөөнөөр борлуулдаг үү, эсвэл жижиглэнгээр борлуулдаг үү зэргийн ялгааг ч ойлгогдохоор бичнэ үү.
 - Уг ажлын байранд 2-с дээш төрлийн өөр ажил хийдэг бол голчлон хийдэг ажлынхаа агуулгыг бичнэ.
 - Жишээлбэл, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ уг байрнаасаа энгийн үйлчлүүлэгчид шууд зарж борлуулдаг бол “-ны үйлдвэрлэл, жижиглэн худалдаа” гэж бичнэ.
 - Томилгооны ажилтан нь уг томилогдон очиж ажиллаж буй газрынхаа ажлын агуулгыг бичнэ.

16. Өөрийн хийдэг ажлын агуулга

- Тухайн ажлын байран дээрээ тухайн хүний өөрийн хийдэг ажлын агуулгыг бичнэ үү.
- “Үнэт цаасны аналит”, “Олон улсын өмгөөлөгч”, “Дизайнер” зэрэг ажлын агуулга бүрэн ойлгогдохуйц нэр байдаг бол уг нэрийг бичнэ.
- 2-с дээш төрлийн өөр ажил хийдэг бол илүү удаан цагаар хийдэг аль нэг ажлынхаа агуулгыг зөвхөн бичнэ үү.
 - Удирдлага, борлуулалт зэрэг ажлаас гадна нийтийн хоол, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, засвар зэрэг тусгай технологи, үр чадвар шаардлагатай ажил хийдэг бол технологи, үр чадвар шаардагддаг ажлаа сонгож агуулгыг нь бичнэ.
 - Жишээлбэл: Хуулийн зөвлөгөө өгөх газар ажиллуулдаг бөгөөд давхар өмгөөлөгчөөр ажилладаг бол “өмгөөлөгч” гэж, ресторан ажиллуулдаг, тэндээ тогооч хийдэг бол “тогооч” гэж бичнэ.
- Томилгооны ажилтан бол томилогдож очсон газартаа өөрийн хийдэг ажлын агуулгыг бичнэ.

15 ба 16-р асуултын хариултыг бичих жишээ:

[Жишээ 1] Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газар ажилладаг бол,

15-р асуултад	Ажлын газрын нэр:	“Аозора автомашин” ХК-н 1-р үйлдвэр
	Ажлын агуулга	Хурд дамжуулагч механизмын үйлдвэрлэл
16-р асуултад	Өөрийн хийдэг ажлын агуулга	Хурд дамжуулагч механизм угсардаг

[Жишээ 2] Үйлчилгээ эрхэлдэг газар ажилладаг бол,

15-р асуултад	Ажлын газрын нэр:	“Тоотарү кэа сэнтаа” ХК
	Ажлын агуулга	Өндөр настнуудын гэрээр очиж үсанд оруулах, хоол хийж өгөх зэрэг асаргааны ажил эрхэлдэг.
16-р асуултад	Өөрийн хийдэг ажлын агуулга	Гэрийн үйлчлэгч

[Жишээ 3] Бөөний худалдаа эрхэлдэг газар ажилладаг бол,

15-р асуултад	Ажлын газрын нэр:	“Рикаа бооэки” ХК
	Ажлын агуулга	Европ архи дарсны бөөний худалдаа
16-р асуултад	Өөрийн хийдэг ажлын агуулга	Бараа нийлүүлэлт

Асуулгын талаар ойлгогдохгүй зүйл байвал доорх хаяг, утсаар лавлана уу.

Хот, дүүрэг, тосгон, суурингийн хаяг, утас: